

ШИНЖЭЭЧДИЙН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ (2023 оны III улирлын түүвэр судалгааны тайлан)

Судалгааны товч үр дүн

Шинжээчдийн макро эдийн засгийн төсөөллийн судалгааг 2023 оны 8 сарын 18-29-ний өдрүүдийн хооронд банкуудын эдийн засагчид, их дээд сургуулиудын багш нар болон судалгааны байгууллагууд, хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын нийт 26 судлаачид (цаашид шинжээч)-ын дунд явуулж, судалгааны үр дүнг дараах байдлаар нэгтгэн танилцуулж байна.

Шинжээчид:

2023 оны III улиралд

- Инфляц бага зэрэг өсөж 10.1%,
- Эдийн засгийн өсөлтийг 6.0%,
- Бодлогын хүү өнөөгийн түвшинд 12.9%,
- Зээлийн хүү өнөөгийн түвшинд 16.7% болно гэж таамагласан байна.

2024 оны II улиралд

- Инфляц өнөөгийн түвшинд 9.2%,
- Эдийн засгийн өсөлтийг 5.6%,
- Бодлогын хүү бага зэрэг буурч 11.5%,
- Зээлийн хүү бага зэрэг буурч 16.0% болно гэж таамагласан байна.

Судалгааны нэгдсэн үр дүн

Огноо	2023 он 7 сар	2023 он III улирал	2024 оны II улирал
Инфляц /ХҮИ-ийн жилийн өсөлт, УБ хот, %/	9.4%	10.1%	9.2%
Эдийн засгийн өсөлт /Бодит ДНБ-ий жилийн өсөлт, %/	6.4%	6.0%	5.6%
Төв банкны бодлогын хүү /%/	13.0%	12.9%	11.5%
Олгосон зээлийн дундаж хүү /₮, %/	16.6%	16.7%	16.0%

Энэхүү улирал тутмын түүвэр судалгааны тайлангийн агуулга нь зөвхөн банкууд, хувь шинжээч, судлаачдын таамаглалыг нэгтгэсэн үр дүнг илэрхийлэх бөгөөд Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

© МОНГОЛБАНК, 2023

I. Инфляц


2023 оны II улиралд Улаанбаатар хотын жилийн инфляц 9.4% болж буурсан бөгөөд энэ нь өмнөх улирлын шинжээчдийн дундаж таамаглалаас 2.0 нэгж хувиар доогуур гарсан байна. Шинжээчид 2023 оны III улиралд инфляц 10.1%, жилийн дараа 9.2% болно гэж таамаглаж байна (Зураг 1).

Зураг 1. Инфляцын таамаглал




Шинжээчдийн инфляцын таамаглалын тархалтыг авч үзвэл 2023 оны III улиралд инфляц 9-өөс 9.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 30.8%-тай байна. Өмнөх улирлын судалгаагаар 2023 оны III улиралд инфляц 10-аас 10.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 23.3% гэж таамаглаж байжээ (Зураг 2).

Зураг 2. Инфляцын таамаглалын тархалт /2023.III улирал/



Энэ удаагийн инфляцын таамаглалын үр дүнг өмнөх түүвэр судалгаануудын таамаглалуудтай харьцуулахад буурах хандлагатай байна. Сүүлийн саруудад инфляц тогтворжин, буурч байгаатай холбоотойгоор шинжээчдийн инфляцын таамаглал буурсан байх талтай. Тухайлбал, шинжээчид 2023 оны III улирлын инфляцыг өмнөх улирлын судалгаагаар 11.1% гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 10.1% гэж таамаглажээ (Зураг 3).


Зураг 3. Инфляцын өмнөх таамаглалуудын харьцуулалт



II. Эдийн засгийн өсөлт


2023 оны II улиралд бодит ДНБ-ий жилийн өсөлт 6.4% гарсан бөгөөд энэ нь өмнөх улирлын шинжээчдийн дундаж таамаглалаас 0.9 нэгж хувиар өндөр гаржээ. Шинжээчид бодит ДНБ-ий жилийн өсөлт 2023 оны III улиралд 6.0%, 2024 оны II улиралд 5.6% гэж таамаглаж байна (Зураг 4).

Зураг 4. Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглал





Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалын тархалтыг авч үзвэл 2023 оны III улиралд 6-аас 6.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 34% байна. Харин өмнөх улирлын судалгаагаар 2023 оны III улиралд өсөлт 5-аас 5.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 28% гэж таамаглаж байжээ (Зураг 5).

Зураг 5. Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалын тархалт /2023.III улирал/



Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалыг өмнөх түүвэр судалгаануудын таамаглалуудтай харьцуулахад өсөх хандлага ажиглагдаж байна. 2022 оны дунд үеэс эдийн засгийн байдал сэргэж эхэлснээр шинжээчдийн эдийн засгийн өсөлтийн таамаглал улирал бүр нэмэгдэж иржээ. Жишээлбэл, шинжээчид 2023 оны III улирлын бодит ДНБ-ий жилийн өсөлтийг өмнөх улирлын судалгаагаар 5.5%-д хүрнэ гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 6.0% байна гэж таамаглажээ (Зураг 6).


Зураг 6. Бодит ДНБ-ий өсөлтийн өмнөх таамаглалуудын харьцуулалт



Ш. Бодлогын хүү


Шинжээчид төв банкны бодлогын хүүг 2023 оны III улиралд дунджаар 12.9%, хамгийн ихдээ 13.0%, хамгийн багадаа 12.0% гэсэн хүлээлттэй байна. Цаашид бодлогын хүү бага зэрэг буурч 2024 оны II улиралд 11.5% байна гэж таамаглажээ (Зураг 7).

Зураг 7. Бодлогын хүүний таамаглал



Бодлогын хүүний таамаглалыг тархалтаар нь авч үзвэл шинжээчдийн дийлэнх нь 2023 оны III улиралд бодлогын хүү 13.0% байна гэсэн таамаглалтай байна (Зураг 8).


Зураг 8. Бодлогын хүүний таамаглалын тархалт /2023.III улирал, хариултын тоогоор/



Бодлогын хүүний таамаглалыг өмнөх улирлын судалгааны таамаглалтай харьцуулахад төдийлөн өөрчлөглөөгүй байна. 2022 оны эхэн үеэс үнийн өсөлтийг хязгаарлах зорилгоор бодлогын хүүг нэмэгдүүлж эхэлсэнтэй холбоотойгоор шинжээчдийн таамаглал улирал бүр нэмэгдэж ирсэн бол энэ улирлын

судалгааны үр дүн өмнөх улиралтай ерөнхийдөө ойролцоо гарчээ. Өмнөх улирлын судалгаагаар шинжээчид 2023 оны III улирлын бодлогын хүүг 12.6% байна таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 12.9% байна гэж таамаглажээ (Зураг 9).


Зураг 9. Бодлогын хүүний өмнөх таамаглалуудын харьцуулалт



IV. Зээлийн хүү


Шинжээчид төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүүг 2023 оны III улиралд дунджаар 16.7%, хамгийн ихдээ 18.0%, хамгийн багадаа 15.4%-тай байна гэж таамаглажээ. Цаашид зээлийн хүү бага зэрэг буурч 2024 оны II улиралд 16.0% орчим байхаар таамагласан байна (Зураг 10).

Зураг 10. Зээлийн хүүний таамаглал



Зээлийн хүүний таамаглалын тархалтаас харвал 2023 оны III улиралд зээлийн жигнэсэн дундаж хүүг 16.5%-17.4% байна гэсэн таамаглал давамгайлж байна (Зураг 11).

Зураг 11. Зээлийн хүүний таамаглалын тархалт /2023.III улирал, хариултын тоогоор/



Зээлийн хүүний таамаглалыг өмнөх түүвэр судалгаануудын үр дүнтэй харьцуулан авч үзвэл бага зэрэг өсөх хандлага харагдаж байна. Бодлогын хүү нэмэгдэж байгаатай холбоотойгоор шинжээчдийн зээлийн хүүний

таамаглал улирал бүр нэмэгдэж иржээ. Тухайлбал, өмнөх улирлын судалгаагаар шинжээчид 2023 оны III улиралд зээлийн хүүг 16.5%-д хүрнэ гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 16.7% гарна гэж үзжээ (Зураг 12).

Зураг 12. Зээлийн хүүний өмнөх таамаглалуудын харьцуулалт

